

Германы Бундестагийн
тогтоолын үндсэн дээр
хөхиүлэн дэмжсэн:




Холбооны
Хүнс,
хөдөө аж ахуйн яам



ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ,
ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН ЯАМ

ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ЗОНХИЛОХ ХОГ УРГАМАЛ, ТЭМЦЭХ АГРОТЕХНИКИЙН АРГУУД



ДАРХАН ХОТ
2021 он



ТАРИАЛАНГИЙН ТАЛБАЙН ЗОНХИЛОХ ХОГ УРГАМАЛ, ТЭМЦЭХ АГРОТЕХНИКИЙН АРГУУД

Төсөл хэрэгжүүлэгч



Тайлбар: Энэхүү гарын авлагыг Герман-Монголын хамтын ажиллагааны “Тогтвортой хөдөө аж ахуй” (MNG 19-01) төслийн хамтын ажиллагааны хүрээнд хэвлэв. Гарын авлагад дурьдагдсан байр суурь, дүгнэлтийн үнэн зөв байдлыг зохиогч хариуцах бөгөөд “Тогтвортой хөдөө аж ахуй” төслийг санхүүжүүлэгч ХБНГУ-ын Хүнс, хөдөө аж ахуйн яамны албан ёсны байр суурийг илэрхийлээгүй болно.

ГАРЧИГ

Технологийн редактор:	Ж.Намбар <i>Доктор Ph, дэд Проф</i> ¹ Б.Баатарцол <i>Доктор Ph, дэд Проф</i> ²
Ургамал судлалын редактор:	Б.Цэрэннадмид <i>Доктор Ph</i> ³
Зохиогчид:	С.Сайханцэцэг <i>Доктор Ph</i> ¹ Ж.Отгон <i>Магистр</i> ²
Хэвлэлийн эх бэлтгэл:	С.Сайханцэцэг <i>Доктор Ph</i> ¹ Ж.Отгон <i>Магистр</i> ²

ӨМНӨХ ҮГ	7
1. ХОГ УРГАМЛЫН ТУХАЙ ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	9
2. ХОГ УРГАМЛЫН ЭКОЛОГИ, БИОЛОГИЙН ОНЦЛОГ	10
3. ХОГ УРГАМЛЫН АНГИЛАЛ	13
4. ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХЭД ТЕХНОЛОГИЙН ЗУРАГЛАЛЫН АЧ ХОЛБОГДОЛ, ТҮҮНИЙГ ЗОХИОХ ҮНДЭСЛЭЛ	19
5. ХОГТОЛТЫН ХЭМЖЭЭГ ТООЦОХ	21
6. ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭ	23
6.1 Урьдчилан сэргийлэх арга хэмжээ	23
6.2 Хог ургамалтай химийн аргаар тэмцэх	26
6.3 Хог ургамалтай агротехникийн аргаар тэмцэх	40
6.4 Хог ургамалтай биологийн аргаар тэмцэх	41
7. МОНГОЛЫН ТАРИАЛАНД ЗОНХИЛОН ТАРХСАН ХОГ УРГАМЛУУД	43
8. ХОГ УРГАМЛЫН ТАРХАЛТЫГ ХЯЗГААРЛАХ АГРОТЕХНИКИЙН АРГА БАРИЛЫГ СУДАЛСАН ДҮНГЭЭС	110
8.1 Хог ургамалтай агротехникийн аргаар тэмцсэн судалгааны дүн	110
9. ТАРИМЛЫГ СЭЛГҮҮЛЭН ТАРИАЛАХ ЗАМААР ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХ ОНЦЛОГ	114
9.1 Таримлыг зөв сэлгэн тариалах замаар хог ургамалтай тэмцсэн судалгааны дүн	114
9.2 Хог ургамлын ургалтыг бууруулж, ургац нэмэгдүүлэх сэлгээ	117
9.3 Хучлагатай таримлын сэлгээний талбайд хийгдсэн судалгааны ажлын үр дүнгээс	119
10. ХӨРС БОЛОВСРУУЛАХ АРГААР ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХ АРГЫГ СУДАЛСАН ДҮНГЭЭС	124
10.1 Хөрс боловсруулах аргаар хог ургамалтай тэмцэх судалгааны дүн	124
10.2 Цулгуй уриншийг хавах технологиор боловсруулах	125
10.3 Хавар, намрын үндсэн боловсруулалт	130
10.4 Хавар эртийн болон тарилтын өмнөх боловсруулап	131
10.5 Хөрсийг хагалж боловсруулж хог ургамалтай тэмцэх зарим онцлог	132
11. ЭРЧИМЖСЭН НӨХЦӨЛД ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХ ЗАРИМ ОНЦЛОГ	137
12. ОЛОН НАСТ ХОГ УРГАМЛЫН ҮРЖЛИЙН НАХИАНЫ СУДАЛГАА	141
13. УСАЛГААТАЙ ТАЛБАЙН ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦЭХ	142
13.1 Ургамал ургалтын хугацаанд буудайн усалгаатай талбайн хог ургамалтай химийн аргаар тэмцэх	142
14. ТАРИМЛЫН ТАЛБАЙН ХОГ УРГАМЛЫН СУДАЛГАА	145
14.1 Буудайн талбайд ургасан хог ургамал	145
14.2 Элдэншүүлэггүй уриншид тарьсан буудайн талбайн хог ургамлын судалгаа	146
14.3 Элдэншүүлэггүй уриншид хучлага үүсгэхээр тариалсан таримлуудын хог ургамлын судалгаа	150
15. УРИНШИЙН ТАЛБАЙД ХОГ УРГАМЛЫН УРГАЛТЫГ БУУРУУЛАХ АЖЛЫН ДҮНГЭЭС	151
15.1 Элдэншүүлэггүй уриншийн талбайн хог ургамлын ургалт ба усталт	151

15.2	Сэлгээний уриншийн талбайн тарилтын өмнөх хог ургамлын судалгаа	155
15.3	Сэлгээний уриншийн талбайн хог ургамлын судалгаа	166
15.4	Атаршсан уриншийн хог ургамлын судалгаа	168
16.	ХУЧЛАГА ҮҮСГЭХ ЗАМААР ХОГ УРГАМАЛТАЙ ТЭМЦСЭН ДҮН	171
16.1	Хучлагатай, хучлагагүй талбайн хог ургамлыг харьцуулан судалсан дүн	171
16.2	Хучлагатай таримал сорилтын талбайн хог ургамлын судалгаа	179
16.3	Тариалангийн хог ургамлын ургалтанд сүрлэн хучлага, таримлын сэлгээний нөлөө	183
17.	ХОГ УРГАМЛЫН ҮРИЙН НӨӨЦИЙН СУДАЛГААНЫ ДҮН	191
17.1	Таримлын сэлгээний талбайн хог ургамлын үрийн нөөцийн судалгаа	191
17.2	Элдэншүүлэггүй уриншийн талбайн хог ургамлын үрийн нөөцийн судалгаа	195
17.3	Хучлагатай, хучлагагүй талбайн хог ургамлыг үрийн нөөц судалсан дүн	197
17.4	Хог ургамлын үрийн нөөцөд сүрлэн хучлагын нөлөө	198
17.5	Хучлагатай таримлын сэлгээний хог ургамлын үрийн нөөцийн судалгаа	199
	ХОГ УРГАМЛЫН НЭРИЙН ХЭЛХЭЭС	202
	АШИГЛАСАН ХЭВЛЭЛИЙН ЖАГСААЛТ	204

Өмнөх үг

Энэхүү номонд хог ургамлын тухай ерөнхий ойлголт, экологи, биологийн онцлог, ангилал, хогтолтын хэмжээг тогтоож тэмцэх аргыг төлөвлөх, үнэлэх, хог ургамалтай тэмцэх арга хэмжээ, Монгол орны тариалангийн талбайд зонхилон тархсан хог ургамлуудын биологийн онцлог болон хог ургамлын тархалтыг хязгаарлах агротехникийн арга барилыг судалсан судлаачдын судалгааны ажлын үр дүнг нэгтгэн бичсэн болно.

Хог ургамалтай тэмцэхийн тулд төрөл, зүйлийг морфологи шинжээр нь ялангуяа ургалтын эхэн үед цухуйц, соёогоор нь сайн таньж, тус бүрийн биологийн онцлогийг мэддэг байх шаардлагатай тул соёололтын болон үрийн зургийг тус номонд оруулав. Хог ургамал нь олон овогт хамрагддагийнхаа хирээр тариалангийн талбайн ургамлын нэг хэсгийг бүрдүүлж биологийн шинжээрээ нэг зүйл нь нөгөөгөө нөхөн, зүйлийн бүрэлдэхүүн нь орчны нөхцөлөө даган байнга хувьсаж байдаг онцлогтой.

Манай оронд үр тарианы аль ч талбайд нилээд тогтонги бүрэлдэхүүнтэй 16-27 зүйл, усалгаатай буюу хүнсний ногооны талбайд 35-40 зүйлийн хог ургамал зонхилон тааралддаг. Олон зүйлийн хог ургамлууд ган, хүйтэн, халуун даах тэсвэрээрээ ямар ч таримлаас илүү, шим тэжээлийн бодисыг таримал ургамлаас илүү ашигладаг, хүчиллэг, давсархаг хөрсөнд ургаж чадах бөгөөд таатай нөхцөл бүрдсэн үед түргэн өсөж, үржиж, тархах олон аргатайгаас гадна, ургалтын хугацааны аль ч үед хөгжлийн үе шатаа түргэн хөөж нөхөөд боловсрох чадвартай байдаг. Тариалангийн талбайн хог ургамал нь таримал ургамалтайгаа өрсөлдөн ургаж хөрсний чийг, шим тэжээлийн бодисын хангамжийг багасгаж улмаар сүүдэрлэх зэрэг сөрөг нөлөө үзүүлснээр таримлын ургац, чанарыг бууруулаад зогсохгүй, зардал нэмэгдүүлж эдийн засгийн хувьд хохирол учруулдаг хор хөнөөлтэй тул тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид нь хог ургамлын төрөл зүйл, биологийн онцлогоос хамааруулж гербицидийг зөв сонгож, түүнийг үр дүнтэй ашигласнаар эдийн засгийн ашгийг хамгийн их байлгахад чиглэгдэх ёстой.

Тариаланчид өөрсдийн эзэмшлийн талбайн хог ургамлыг таньж тодорхойлсноор шинжлэх ухааны үндэслэлтэй хог ургамалтай тэмцэх аргаа зөв зохион байгуулж тогтвортой өндөр, цэвэр ургац хураан авах ажлыг зохион байгуулахад тус дэм болох зорилгоор энэхүү номыг хэвлүүлэв.